

ТӨРИЙН ИННОВАЦИЙН ОНОВЧТОЙ БОДЛОГООР ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES REGARDING THE PROVISION OF ECONOMIC SECURITY THROUGH RATIONAL STATE INNOVATION POLICY



Хууль сахиулахуй

Д.ДЭМБЭРЭЛ

Хууль сахиулахын их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч, Монгол Улсын их сургуулийн докторант

DEMBEREL D.

(Ph.D. Candidate at NUM & Police Major) Senior Lecturer at the Law and Social Science School of the Law Enforcement University of Mongolia

Abstract: In recent years, one of the most important factors for providing economic security in the country has been the creation of new innovation and technology – which is based upon production, fair competition, conduction of research and the preparation of future human capital. This accumulation of experiences has been largely supported by governmental policies. In this paper, we have clarified the situation on how the Mongolian government has focused on this issue and have also pointed out the urgent needs to address some of the issues that have come into existence based upon notable experience of other foreign countries.

Эдийн засгийн аюулгүй байдал Үндэсний аюулгүй байдлын бүрдэл хэсэг болдог учир эхлээд үндэсний аюулгүй байдал гэж юу болох, юугаар тодорхойлогддог зэргийг товч дурдъя.

Үндэсний аюулгүй байдал бол тусгай хувь хүнээс эхлэн төр-улс тэргүүнийг, гэр бүлээс эхлэн үндэстэн, нийгмийн нийтлэгүүд хүртэлх нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан цогцолбор ойлголт буюу асуудал юм. Үндэсний аюулгүй байдал¹ гэдэгт тухайн улс орны нийгэм-улс төрийн байгуулал, шашин шүтлэг, ёс суртахуун, түүх, соёл, хэл яриа, эдийн засгийн хөгжлийн түвшин, оюуны чадамж, техник технологи зэрэг олон хүчин зүйлээр тодорхойлогдоно.

Эдийн засгийн аюулгүй байдал улс орны эдийн засгийн тогтвортой хөгжил, бие даасан байдал, шинэчлэгдэх чадварыг байнга нөхөн үйлдвэрлэж, зайлшгүй нөлөөлөх хүчин зүйлүүдийг ашиглаж, төрөл

бүрийн арга хэрэгсэл дээр тулгуурлан хангах зорилготой байдаг. Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын түүхэн асуудал улс гүрэн оршин тогтнох, үндэсний болон эдийн засгийн ашиг сонирхол бүрэлдэн тогтох үеэс бий болж, аливаа улс орны түүхэн хөгжлийн үйл явцад хурцаар болон ажиглагдахгүй байдлаар илэрч байдаг бөгөөд хэзээ ч устаж үгүй болдоггүй.

Манай улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Эдийн засгийн аюулгүй байдал гэж дотоод нөөц бололцоогоо ашиглан, нөхөн үйлдвэрлэл явуулах, ард түмнийхээ хэрэгцээг хангах, тусгаар тогтносон байдлыг бэхжүүлэх, эдийн засгийн чадавхтай байх, шаардлагатай нөхцөлд улс орноо тодорхой хугацаагаар тэтгэж чадах эдийн засгийн бүтэц бүрэлдсэн байх явдал” гэж заасан байдаг.²

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал нь хүн амын амьдралын түвшинг бууруулах, үндэсний үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах магадлалтай гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөнд авталгүйгээр эдийн засаг нийгмийн тогтвортой хөгжлийг бодитой хангаж чадахуйц, дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай, харьцангуй бие даасан шинжтэй, харилцан холбоо уялдаа, нэгдмэл байдлыг гүнзгий бодолцсон эдийн засгийн цогцолбор бүтэц бүрэлдэх нөхцөл болно.

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөлүүд нь шинжлэх ухаан, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, байгалийн баялгийг үр ашигтай зарцуулах, хөрөнгийг үр ашигтай хуримтлуулах, дотоодын хөрөнгө оруулалтын

¹ Ч.Улаанхүү. “Аюулгүй байдлын онол арга зүйн асуудал”. УБ., 2014.

² Д.Тунгалаг, Д.Цэрэнпил. “Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын зарим асуудал”. УБ., 2003. 14 дэх тал.

эх үүсвэрийг өсгөх, давуу талаа хөгжүүлэх, дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, нөөц баялгийг үр ашигтай зарцуулах, гадаадын зээлийг ашиглах зэрэг хүчин зүйлсээс бүрдэж байна. Эдгээр хүчин зүйлийг эдийн засгийн өсөлт, дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

Аль нэг улсын төрийн инновацийн бодлого нь эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн бодлогын бүрэлдэхүүний маш чухал хэсэг бөгөөд бүс нутаг, улс орны хийгээд улс хоорондын харилцаанд баримтлах инновацийн бодлогыг чиглүүлэх суурь, үндэс болно.

Орчин үед мэдлэг оюуны үнэ цэнэ үлэмж нэмэгдэж, эдийн засгийн нөөц, үйлдвэрлэлийн чухал хүчин зүйлийн үүрэг гүйцэтгэх болж, түүнд тулгуурласан эдийн засаг бүрэлдэн тогтох үйл явц эрчимтэй өрнөж байна. Энэ нь улс орны ирээдүйн хөгжлийн чиг хандлага инновацитай салшгүй холбоотой байх нөхцөл болж байна. Инноваци өрсөлдөх чадварыг бий болгоод зогсохгүй, нийгэм эдийн засгийн хөгжлийн гол хүчин зүйл, хөдөлгөгч хүч бөгөөд үйлдвэрлэлийг өсөлтийг хангаж, улмаар эдийн засгийн дэвшилд хүргэдэг болохыг бүх нийтээр хүлээн зөвшөөрч байна. Товчоор инноваци нь:

Процесс, бүтээгдэхүүн, үйлчилгээнд дэвшилт гаргахуйц шинэ санаа олох, энэ шинэ санааг хөгжүүлэх концепци боловсруулах, концепцийг зах зээл, хэрэглээнд нэвтрүүлэх үйл явц гэж тодорхойлж болно.

Үүнтэй холбоотойгоор, аливаа улс орны хөгжлийн түвшин инновацийн идэвхжилээр тодорхойлогдоно хэмээн үзэх болж, олон улс орон өөрийн онцлогт тохирсон төрийн инновацийн бодлого боловсруулан хэрэгжүүлж, Үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлж, мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурийг тавьж чадсанаар ихээхэн амжилтад хүрэх боломжтой юм. Сүүлийн жилүүдэд энэ талаар зарим тодорхой алхмууд хийгдэж байгаа.

Тухайлбал: Засгийн газрын 2007 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх Мастер төлөвлөгөөнд технологийн инновацид түшиглэн эдийн засгийг шинэчлэх зорилтыг тавьсан байна. Уг Мастер төлөвлөгөөнд “Шинжлэх ухаан, технологийн чадавхыг бэхжүүлэх, үндэсний инновацийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх хөгжүүлэх, эдийн засгийн тэргүүлэх салбаруудын

технологийн шинэчлэлийг дотоод судалгаа, боловсруулалтын ажлын үр дүн болон гадаадын дэвшилтэт технологийн ололтыг нутагшуулахтай хослуулах замаар хэрэгжүүлэх бодлого явуулна”³ гэж заасан байдаг.

Төрөөс аж үйлдвэрлэл ялангуяа технологийг хөгжүүлэх чиглэлээр томоохон хууль эрх зүйн зохицуулалтыг хийсэн гэдэг. 2000 оноос хойш төрөөс аж үйлдвэрийн салбарын талаар бодлого хөтөлбөрүүдийг боловсруулж баталсан.

Тухайлбал: 1998 онд “Технологи дамжуулах тухай” хууль;

2007 онд “Жижиг дунд үйлдвэрийн тухай” хууль;

2009 онд “Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн тухай” хууль;

2001 онд “Шинжлэх ухаан технологийн тухай хууль”⁴

Мөн Монгол Улсын Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрт: Дэлхий дахины хөгжлийн чиг хандлага инновацийн идэвхжилээр тодорхойлогдох болсон өнөөгийн нөхцөлд улс орнууд өөрийн онцлогт тохирсон инновацийн хөгжлийн бодлого боловсруулан хэрэгжүүлж, үндэсний инновацийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэх явдал ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдгийг хөгжингүй орнуудын туршлага харуулж байна. Иймээс инновацийн удирдлага, түүнийг хэрэгжүүлэх арга механизмын онол практикийн ололтыг судалж нэвтрүүлэх явдал хөгжлийн түвшингээр хоцорч буй орнууд, тэр дундаа манай улсын цаашдын хөгжилд шийдвэрлэх ач холбогдолтой юм.

Эдийн засгийн салбар дахь Инноваци гэдэг нь шинэ эхлэл буюу зохион бүтээх болон бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, арилжаа борлуулалт зэрэгт шинэ арга барилаар хандах хандлагын тухай ойлголт бөгөөд, инновацийн үр дүнд хөрөнгө оруулагч хийгээд түүний үйлдвэр, компани зах зээлд тогтвортой нийлүүлэгч байхын төлөө өрсөлдөөнд давуу байдал олж эзэмших болно. Түүгээр ч барахгүй, шинийг эзэмших эрх эдлэгч тодорхой хугацаанд зах зээл дээр дангаар ноёрхох монополь тогтоож болно.

Инновацийн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ялангуяа төрийн зүгээс

³ “Төрийн мэдээлэл сэтгүүл”. №4 УБ., 2007.

⁴ Г.Баттулга, Д.Төгөлдөр. “Төрөөс шинэ техник технологи, инновацид суурилсан үйлдвэрлэлийг дэмжих зарим асуудал” ЭДИЙН ЗАСАГ сэтгүүл. УБ., 2017. №01/055/ 9 дэх тал.

анхааралдаа авч дэмжлэг үзүүлэхэд:⁵

1. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх, үүний тулд улсын төсөв, төсвийн бус сангууд тухайлбал: инновацийн үйл ажиллагааг санхүүжүүлэх тусгай нэр заасан сантай ч байж болно.

2. Үйлдвэрлэл, технологийн, тухайлбал: инноваци-технологийн төв, бизнес инкубатор гэх мэт бодит материаллаг нөөц сан байгуулж ашиглах

3. Мэдээллийн, тухайлбал: үзүүлэн таниулах материалаар төхөөрөмжилсөн, чөлөөтэй нэвтрэн орж танилцах боломжтой, судалгаа, шинжилгээ, статистик мэдээлэл, сурталчилгааны төв байгуулж ажиллуулах

4. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, тэдгээрийг давтан сургах хийгээд шинжлэх ухааны инновацийн удирдлага, технологийн аудит, маркетингийн чиглэлээр семинар, богино хугацааны сургалт, курс зохион байгуулах

5. Мэргэжлийн шинжээч, эрдэмтэн судлаачдын оюуны бүтээлийн баталгаа гаргаж өгөх, зөвлөгөө өгөх төв ажиллуулах ба уг төвөөр дамжуулан санхүү, хөрөнгө оруулалт, маркетинг, удирдлага гэх мэт чиглэлээр мэргэжлийн шинжээчдээр зөвлөгөө өгүүлэх гэх мэт үйл ажиллагаа, арга хэлбэрээр инновацийн төрийн салбарын хэрэгжилтийг дэмжих хэрэгтэй юм.

Орчинд үед инноваци улс орнууд хийгээд дэлхий дахины эдийн засгийн тогтвортой хөгжлийн нэг чухал хүсэн хүлээдэг хүчин зүйл болж хувирч байна. Тухайлбал шинжлэх ухааны нээлтүүд томоохон зохион бүтээх үйлдлүүд инновацийн суурь үндэс бөгөөд, энэ нь техник технологийн шинэ эриний суурь үндэс болж байдаг. Жишээ нь: Жилд гарах шинэ бүтээлд патент олгож байгаа тоон үзүүлэлтийг эдийн засгийн өсөлт өндөр байгаа улс орнуудтай харьцуулбал: /2015 оны байдлаар/

№	Улс орнууд	Шинэ патентын тоо
1	Бүгд найрамд Солонгос улс	90.000
2	АНУ	180.000
3	Япон улс	250.000
4	БНХАУ	400.000 ¹
5	Монгол Улс	34

Дээрх харьцуулсан улс орнууд шинэ санаа бүтээлийн тоогоор дэлхийд тэргүүлдэг ба дийлэнх нь мэдээллийн технологи, цахилгаан бараа, автомашин гар утас зэрэг бүтээгдэхүүнд авдаг аж. /Үүнд ашигтай загварын гэрчилгээ, зохиогчийн эрхийн гэрчилгээ зэргийг оруулаагүй болно./

Монголын Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс жил бүр гаргадаг Монгол Улсын Өрсөлдөх Чадварын 2014 оны тайланд орсон инновацийг хөгжүүлэхэд гол хүчин зүйл болох үзүүлэлтийг тоймлон үзүүлэхийг зорилоо. Ингэхдээ Олон улсын удирдлагын хөгжлийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг дэлхийн өрсөлдөх чадварын жилийн нэр бүхий 14 оронтой Монгол Улсын өрсөлдөх чадварыг харьцуулан дүгнэсэн байна. Үүнээс Монгол Улсын эдийн засгийн сул тал болж буй нэгэн үзүүлэлт нь технологийн ба шинжлэх ухааны дэд бүтэц хамаарч байв. Эдгээр судалгааны ихэнх нь улс орнуудын дотоод эх сурвалж болон үндэсний статистик мэдээлэл дээр үндэслэн, зарчмыг нь санал асуулгаар тодруулсан болно.

Технологийн салбарын зарим үзүүлэлтийн судалгааг харуулбал:

Хууль эрх зүйн орчин нь технологийн хөгжил ба хэрэглээг чөдөрлөж байна уу, эсвэл дэмжиж байгаа эсэх санал асуулга дээр:

Эрэмбэ	Улс орнууд	Санал асуулга
Сингапур ²		8.07
Малайз		7.76
Катар		6.64
Казакстан		6.33
Чили		6.13
БНСУ		6.03

⁵ Вечканов.Г.С. "Эдийн засгийн аюулгүй байдал" УБ., 2011.



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХ
УНДГАС

Тайланд		5.83
Мексик		5.44
ОХУ		5.32
Украйн		5.13
Перу		4.85
Словак		4.69
Монгол		4.69
Болгар		4.53
Словени		4.00

Энэ мэтчилэн дээрх сонгосон 14 оронтой технологийн дэд бүтцийн салбарт дараах асуултуудаар судалгаа хийхэд:

- ✓ Компаниудын технологийн хамтын ажиллагаа сул, эсвэл сайн эсэх 14 дүгээр байр;
- ✓ Төр, хувийн хэвшлийн түншлэлээр технологийн дэвшлийг дэмжиж чаддаг эсэх санал асуулгын дүнд 14 дүгээр байрт;
- ✓ Дэвшилтэт технологийг санхүүжүүлэх хөрөнгө оруулалт хангалттай эсэх сүүлийн байр буюу 15 дугаар байрт;
- ✓ Технологийн орчны эрх зүйн зохицуулалт нь бизнесийн хөгжил болон инновацид дэмжлэг болдог эсэх асуултад 14 дүгээр байрт тус тус эрэмбэлэгдсэн байна.

Монгол Улс дэвшилтэд технологийн экспортоор ямар үзүүлэлттэй байгааг харуулбал: /2012 оны гадаад худалдааны бараа бүтээгдэхүүний экспортод эзлэх хувиар/⁶

Эрэмбэ	Улс орнууд	%
	Сингапур	45.29
	Малайз	43.71
	Казакстан	29.97
	БНСУ	26.17
	Тайланд	20.54
	Мексик	16.33
	Словак	9.30
	ОХУ	8.38
	Болгар	7.75
	Украйн	6.30
	Словени	6.18
	Чили	4.64
	Перу	3.49
	Монгол	0.30
	Катар	0.04

Сансрын хөлөг, компьютер, эм, электрон техник, шинжлэх ухааны багаж зэмсэг зэрэг судалгаа шинжилгээ шаардсан бүтээгдэхүүнийг экспортын дэвшилтэт технологийн экспорт гэнэ. Гэтэл энэ нь манай улсын бараа бүтээгдэхүүний экспортод 0.30% буюу бараг байдаггүй гэхээр үзүүлэлттэй байна. Экспортоос олдог мөнгөн дүнгээр нь илэрхийлбэл /сая ам.доллар/ Монгол Улс жилдээ 9 сая доллар олдог буюу мөнөөх 14 дүгээр байрт эрэмбэлэгдэж байхад 1 дүгээр байрт эрэмбэлэгдсэн Сингапур улс энэ чиглэлийн бүтээгдэхүүнээр жилдээ 128.239 сая ам.доллар олдог, манай улсын өмнө, 13 дугаар байрт эрэмбэлэгдсэн Перу улс гэхэд жилдээ 185 сая ам.доллар олдог гэсэн судалгаа байна.

Шинжлэх ухааны салбарын хувьд:

⁶ Мөн тэнд.

Эрэмбэ	Улс орнууд	Тоо
БНСУ		25,593
ОХУ		14,151
Сингапур		4,543
Мексик		4,173
Тайланд		2,304
Малайз		2,092
Чили		1,979
Украйн		1,727
Болгар		1,239
Словак		1,099
Словени		650
Перу		162
Катар		111
Казакстан		87
Монгол		25

金瓶梅詞話

г. Гадаадын эрдэмтэн, судлаачдыг татах тухайн улсын чадвар сайн, сул эсэхийг санал асуулгын аргаар тодруулахад Монгол Улс мөн 9 дүгээр байрт 3.41 гэсэн үнэлгээтэй эрэмбэлэгдэж байв.

е. Оюуны өмчийг хамгаалах орчин сайн хөгжсөн эсэх асуулга дээр сүүлийн байрт эрэмбэлэгдсэн зэрэг дүр зурагтай байна.

Ийнхүү дээрх 2 салбарын байдал сул үзүүлэлтэй байгаа нь төрийн бодлогод зайлшгүй тусгах өнөөгийн тулгамдсан асуудлын нэг болох ёстой, анхаарал хандуулах зайлшгүй шаардлага гэж үзэж байна. Инновацийг хөгжүүлье гэвэл суурь асуудлыг нэн тэргүүнд авч үзэх шаардлагатай юм.

- Өндөр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулж тэргүүн ээлжид урт хугацааны зээл олгодог тогтолцоог нэвтрүүлэх.

- Дотоодод үйлдвэрлэсэн өндөр технологийн бүтээгдэхүүнийг экспортлох татварыг тодорхой хугацаагаар тэглэх.

- Өндөр технологийн бараа, бүтээгдэхүүний үзэсгэлэн, худалдаа зохион байгуулах.

- Үр ашиг, ирээдүйтэй технологийг импортлоход хөрөнгө оруулалтын зээл олгох, баталгаа гаргах, татварын хөнгөлөлт үзүүлэх гэх мэт.

Энд мөн Монголын эдийн засгийн өсөлтөд олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн нөлөөллийн шинжилгээг үндэсний статистикийн хорооноос хийсэн мэдээллийг үзүүлэхэд:

Монгол Улсын ДНБ ба аж үйлдвэрийн олборлох, боловсруулах салбарын хамаарлыг Кобба-Дугласын функцээр тодорхойлсон нь⁷

⁷ Г.Баттулга, Д.Төгөлдөр. “Төрөөс шинэ техник технологи, инновацид суурилсан үйлдвэрлэлийг дэмжих зарим асуудал” Эдийн засаг сэтгүүл. УБ., 2017 №01/055 / 10 дахь тал

Он	2009	2010	2011	2012	2013	2014	2015
ДНБ /их наяд төгрөг/	6,5	6,6	8,4	13,2	16,7	19,1	21,8
Олборлох салбар х1 /их наяд төгрөг/	1,32	1,28	1,91	2,53	2,74	2,96	3,1
Боловсруулах салбар х2 /их наяд төгрөг/	0,43	0,42	0,54	0,93	1,25	1,70	1,95

Судлаачид энэхүү функцийг логарифм хэлбэрт хувиргаж, улмаар 2009-2015 оны хугацааны ДНБ, олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн өгөгдөлд суурилан E-VIEW S7 програмаар тооцоолж үзэхэд:

Олборлох салбарын бүтээгдэхүүний гаргалтыг 1 хувиар нэмэгдүүлэхэд Монгол Улсын ДНБ нь 0,34 хувь, боловсруулах салбарыг мөн адил 1 хувиар нэмэгдүүлэхэд ДНБ нь 0,59 хувиар өссөн тооцоолол гарсан байна. Олборлох салбарын өсөлтөөс илүүгээр боловсруулах салбарын өсөлт Дотоодын нийт бүтээгдэхүүнд нөлөөлж байна. Энэ нь олборлох салбараас илүүгээр инноваци байнга нэвтрүүлэх боломжтой боловсруулах салбарыг хөгжүүлэх нь чухал гэсэн санааг илэрхийлж байна.

ДҮГНЭЛТ

Орчин үед аль нэг орон өөрийн ямар нэг давуу талыг өөртөө өгөөжтэй, үр ашигтай ашиглахад эдийн засаг, үйлдвэрлэл, үйлчилгээнд инновацийн идэвхжилийг эрчимжүүлэх хэрэгтэй бөгөөд инновацийг идэвхжүүлэх боломж ч харьцангуй нээлттэй болсныг зориуд тэмдэглэх хэрэгтэй. Гагцхүү инновацийг идэвхжүүлэхэд Монголын төрийн үүрэг, үйл ажиллагаа зохистой буюу шинжлэх ухаан, техник технологийн ололт амжилтыг төрийн шугамаар сурвалжлан, үйлдвэрлэгчдэд санал болгоод зогсохгүй бүх талаар инновацийн идэвхжилийг эзэмших нь өдөр ирэх бүр чухал шаардлагын нэг болсоор байна.

Өнөө үед эдийн засгийг инновациар загваржуулахыг хүсэмжлэх болсон нь нөгөө талаар том том үйлдвэрийг ажиллуулах түүхий эд, нөөц хомсдолд өртөгдөж, урьд өмнө үйлдвэрлэж хэрэглэснээ дахин үйлдвэрлэж хэрэглэхээс өөр гарцгүйдэж, инновацид түшиглэсэн хаягдалгүй үйлдвэрлэл буюу хаягдлыг хаягдал биш харин бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх материаллаг нөөц гэж үзэж дахин давтан хэрэглэхээс өөр гарц нэгэнт олдохгүй байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна.

Ийнхүү инновацчилсан эдийн засаг нь орчин үе буюу шинэ эриний эдийн засгийн харилцааны шинэ хэв загвар бөгөөд түүний хөгжлийн үндэс суурь нь хүн амын оюуны болон технологийн чадавх юм.

Инноваци нь эцэстээ эдийн засгийн аюулгүй байдлыг хангах гол арга замын нэг зайлшгүй болж, улмаар тухайн улсын өрсөлдөх чадварыг илтгэх чухал үзүүлэлт болж байна. Судалгаанд инновацийг хөгжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлүүдийн сул байгаа үзүүлэлтүүдэд Монгол Улсын төр анхаарлаа хандуулж, эдийн засгийн ухаалаг бодлого хөтөлбөрөөр идэвхтэй зохицуулалт хийх шаардлага бий боллоо.

Өрсөлдөх чадвар бол ерөнхийдөө экспортод тусгалаа олдог. Улс орон өрсөлдөх чадвар сайтай байна гэдэг нь тэдний бүтээгдэхүүн, үйлчилгээ бусад улсаас илүү байна гэсэн үг. Үүнд төрийн инновацийн зөв оновчтой бодлого хамгийн их нөлөө үзүүлсэн байдаг.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Д.Тунгалаг, Д.Цэрэнпил. "Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын зарим асуудал" УБ., 2013.
2. Вечканов Г.С. "Эдийн засгийн аюулгүй байдал". УБ., 2011.
3. "Төрийн мэдээлэл" сэтгүүл №4. УБ., 2007.
4. "Эдийн засаг" сэтгүүл №01/055/. УБ., 2017.
5. "Боловсролын инноваци сэтгүүл" №1 УБ., 2015.
6. "Бизнес таймс" сонин.
7. "Монгол Улсын өрсөлдөх чадварын тайлан". УБ., 2014.
8. "Статистикийн бюллетень". УБ., 2014/12.
9. www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=412630
10. <https://sisi.num.edu.mn/.../Оюуны%20өмчийн%20хөрөнгийн%20үнэлгээ-Бүлэг%2>